ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/155/НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын захирал: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбарын аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас:99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/105

танай ________-ны № ________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮҮХЭД,
ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.ДАШБАЯР ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн хөгжлийн сангийн санхүүжилт, аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны 10 дугээр сарын 09-ний өдрийн 1/266 тоот зөвшөөрлөөр 4,653.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/108 тушаалаар 4,250.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна.Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 22,407.4 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлж 5,766.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 16,640.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн

### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймаг дахь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын даргаар 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 хөтөлбөр, 47 арга хэмжээтэй батлуулж, 97.7 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **67,837,268.00** | **57,829,798.85** |
| **33** | **АВЛАГА** | 968,891.00 | 3,516,789.85 |
| **335** | **Бусад авлага** | 968,891.00 | 3,516,789.85 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 968,891.00 | 3,516,789.85 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 66,868,377.00 | 54,313,009.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 25,000.00 | - |
| 35130 | Эм боох материал | 25,000.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 66,843,377.00 | 54,313,009.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,349,900.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 22,963,774.00 | 20,263,056.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 40,529,703.00 | 34,049,953.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,294,719,962.41** | **2,346,851,202.26** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,294,719,962.41 | 2,346,851,202.26 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,208,970,629.05 | 2,263,080,868.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,269,226,526.00 | 2,269,226,526.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (226,922,652.72) | (264,743,094.84) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 25,000,000.00 | 7,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (25,000,000.00) | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 181,370,516.46 | 294,886,087.46 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (58,321,214.39) | (85,036,129.73) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 63,421,753.50 | 66,572,813.70 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21,735,824.12) | (27,211,704.64) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,581,734.00 | 2,581,734.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (650,209.68) | (695,363.13) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 85,749,333.36 | 83,770,333.44 |
| 39301 | Програм хангамж | 6,820,000.00 | 6,820,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,720,666.64) | (3,699,666.56) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 80,650,000.00 | 80,650,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,362,557,230.41** | **2,404,681,001.11** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **7,019,489.05** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 7,019,489.05 |
| **413** | **Өглөг** | - | 7,019,489.05 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 7,019,489.05 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,362,557,230.41** | **2,397,661,512.06** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,362,557,230.41 | 2,397,661,512.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 208,224,021.00 | 208,224,021.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 208,224,021.00 | 208,224,021.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 944,345,510.10 | 979,449,791.75 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 944,345,510.10 | 944,345,510.10 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 35,104,281.65 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,209,987,699.31 | 1,209,987,699.31 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,362,557,230.41** | **2,404,681,001.11** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,815,903,519.00** | **3,209,291,375.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,466,068,108.00** | **-** |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 1,466,068,108.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 1,466,068,108.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **349,835,411.00** | **3,209,291,375.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | 2,676,349,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,676,349,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 349,835,411.00 | 532,941,775.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 15,000,000.00 | 51,209,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 319,635,411.00 | 451,757,175.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,200,000.00 | 29,975,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,859,910,444.46** | **3,322,468,377.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,859,910,444.46** | **3,287,364,094.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,408,646,723.06 | 2,671,985,721.77 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 501,303,400.10 | 1,362,723,485.00 |
| 210101 | Үндсэн цалин | 275,686,599.00 | 805,018,205.00 |
| 210102 | Нэмэгдэл | 94,266,657.00 | 270,998,718.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,555,000.00 | 161,762,350.00 |
| 210104 | Урамшуулал | 27,729,851.00 | 53,711,337.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 69,065,293.10 | 71,232,875.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,003,635.58 | 165,959,884.16 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,174,342.79 | 114,584,405.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,077,940.12 | 13,934,763.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,518,181.74 | 6,922,725.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,252,344.58 | 6,171,347.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,980,826.35 | 24,346,641.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 195,718,891.43 | 273,974,189.05 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,004,418.89 | 10,408,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 183,258,971.54 | 256,493,789.05 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,455,501.00 | 7,071,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,754,233.00 | 57,617,088.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,090,200.00 | 16,288,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,066,820.00 | 12,733,080.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 749,213.00 | 2,157,810.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 268,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 295,000.00 | 1,320,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,553,000.00 | 13,091,330.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 11,757,368.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 139,305.00 | 15,876,122.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 139,305.00 | 890,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 11,165,742.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 3,819,580.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,208,800.00 | 14,574,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 13,208,800.00 | 14,574,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 241,400.00 | 5,561,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 241,400.00 | 5,561,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 530,697,702.00 | 626,284,012.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 528,516,769.00 | 622,002,798.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 71,381.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 13,500.00 | 56,662.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 644,500.00 | 2,773,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 241,952.00 | 241,952.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 93,579,355.95 | 149,415,241.56 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,318,600.00 | 62,701,480.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 92,260,755.95 | 86,713,761.56 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 451,263,721.40 | 615,378,372.99 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,017,140.00 | 3,024,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,699,708.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,875,032.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,442,400.00 | 3,024,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 408,686,581.40 | 611,385,481.99 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 408,686,581.40 | 611,385,481.99 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,560,000.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,560,000.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **204.771.05** | **(35.104.281.65)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **204.771.05** | **(35.104.281.65)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,815,903,519.00** | **3,210,260,266.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **968,891.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 968,891.00 |
| 120009 | Бусад орлого | - | 968,891.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,815,903,519.00** | **3,209,291,375.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,466,068,108.00 | 2,676,349,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,676,349,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 349,835,411.00 | 532,941,775.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 15,000,000.00 | 51,209,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 319,635,411.00 | 451,757,175.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,200,000.00 | 29,975,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,375,787,507.11** | **3,183,807,766.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,375,787,507.11** | **3,183,807,766.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,333,210,367.11** | **2,564,978,393.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 501,303,400.10 | 1,362,723,485.00 |
| 210101 | Үндсэн цалин | 275,686,599.00 | 805,018,205.00 |
| 210102 | Нэмэгдэл | 94,266,657.00 | 270,998,718.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,555,000.00 | 161,762,350.00 |
| 210104 | Урамшуулал | 27,729,851.00 | 53,711,337.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 69,065,293.10 | 71,232,875.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,003,635.58 | 166,025,674.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,174,342.79 | 114,650,195.57 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,077,940.12 | 13,934,763.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,518,181.74 | 6,922,725.58 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,252,344.58 | 6,171,347.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,980,826.35 | 24,346,641.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 195,718,891.43 | 266,954,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,004,418.89 | 10,408,800.00 |
| 210302 | Түлш, халаалт | 183,258,971.54 | 249,474,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,455,501.00 | 7,071,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,000,633.00 | 45,084,220.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,440,100.00 | 12,939,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,066,820.00 | 12,733,080.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 749,213.00 | 2,157,810.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 268,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 295,000.00 | 1,320,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,449,500.00 | 15,665,730.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,305.00 | 15,851,122.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 99,305.00 | 865,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | - | 11,165,742.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 3,819,580.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,308,800.00 | 15,274,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 660,000.00 | 700,000.00 |
| 210602 | Тавилга | 440,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 13,208,800.00 | 14,574,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 241,400.00 | 5,561,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 241,400.00 | 5,561,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 537,215,702.00 | 624,802,012.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 535,034,769.00 | 620,520,798.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 | 1,209,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 71,381.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 13,500.00 | 56,662.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 644,500.00 | 2,773,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 241,952.00 | 241,952.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,318,600.00 | 62,701,480.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,318,600.00 | 62,701,480.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **42,687,570.49** | **618,829,372.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,017,140.00 | 3,024,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,699,708.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,875,032.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,442,400.00 | 3,024,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 615.805.372.99 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 615.805.372.99 |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | | 968,891.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,560,000.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,560,000.00 | - |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 110,430.49 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **440,005,581.40** | **26,452,500.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **26,452,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **26,452,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 26,452,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 26,452,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(26,452,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **440,005,581.40** | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцоо | Дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 208,224,021.00 | 1,209,987,699.31 | 944,140,739.05 | 2,362,352,459.36 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 204,771.05 | 204,771.05 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 208,224,021.00 | 1,209,987,699.31 | 944,345,510.10 | 2,362,557,230.41 |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 35,104,281.65 | 35,104,281.65 |
| 18 | . . . . . . . . . . . . . . . . | | | | |
| 19 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 208,224,021.00 | 1,209,987,699.31 | 979,449,791.75 | 2,397,661,512.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| **Данс** | **Үзүүлэлт** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,676,349,600.00 | 2,058,489,118.01 | 617,860,481.99 | 76.91 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,676,349,600.00 | 2,058,489,118.01 | 617,860,481.99 | 76.91 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,659,353,600.00 | 2,058,489,118.01 | 600,864,481.99 | 77.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,398,110,000.00 | 1,291,490,610.00 | 106,619,390.00 | 92.37 |
| 210101 | Үндсэн цалин | 836,325,400.00 | 805,018,205.00 | 31,307,195.00 | 96.26 |
| 210102 | Нэмэгдэл | 318,129,000.00 | 270,998,718.00 | 47,130,282.00 | 85.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 192,377,800.00 | 161,762,350.00 | 30,615,450.00 | 84.09 |
| 210104 | Урамшуулал | 51,277,800.00 | 53,711,337.00 | (2,433,537.00) | 104.75 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 187,023,400.00 | 158,246,061.01 | 28,777,338.99 | 84.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 127,204,700.00 | 109,200,734.57 | 18,003,965.43 | 85.85 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 14,976,600.00 | 13,094,553.24 | 1,882,046.76 | 87.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,488,200.00 | 6,518,673.58 | 969,526.42 | 87.05 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,470,800.00 | 5,886,347.94 | 1,584,452.06 | 78.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 29,883,100.00 | 23,545,751.68 | 6,337,348.32 | 78.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 271,931,800.00 | 266,954,700.00 | 4,977,100.00 | 98.17 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,408,800.00 | 10,408,800.00 | - | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 254,451,400.00 | 249,474,300.00 | 4,977,100.00 | 98.04 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,071,600.00 | 7,071,600.00 | - | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 127,645,800.00 | 24,918,220.00 | 102,727,580.00 | 19.52 |
| 210401 | Бичиг хэрэг | 33,451,800.00 | 5,403,400.00 | 28,048,400.00 | 16.15 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,859,900.00 | 12,733,080.00 | 24,126,820.00 | 34.54 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 10,218,300.00 | 2,157,810.00 | 8,060,490.00 | 21.12 |
| 210404 | Ном, хэвлэл | 39,127,400.00 | 268,500.00 | 38,858,900.00 | 0.69 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,581,100.00 | 816,100.00 | 1,765,000.00 | 31.62 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,407,300.00 | 3,539,330.00 | 1,867,970.00 | 65.45 |
| **2105** | **Нормативт зардал** | 52,630,900.00 | 15,616,662.00 | 37,014,238.00 | 29.67 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 7,642,500.00 | 631,340.00 | 7,011,160.00 | 8.26 |
| 210502 | Хоол, хүнс | 31,918,800.00 | 11,165,742.00 | 20,753,058.00 | 34.98 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 13,069,600.00 | 3,819,580.00 | 9,250,020.00 | 29.22 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 35,323,800.00 | 5,561,600.00 | 29,762,200.00 | 15.74 |
| 210702 | Дотоод албан томилолт | 35,323,800.00 | 5,561,600.00 | 29,762,200.00 | 15.74 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 477,680,900.00 | 232,999,785.00 | 244,681,115.00 | 48.78 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 474,794,300.00 | 232,233,423.00 | 242,560,877.00 | 48.91 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,971,000.00 | - | 1,971,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 58,600.00 | - | 58,600.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 50,400.00 | 46,662.00 | 3,738.00 | 92.58 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 29,600.00 | - | 29,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 557,300.00 | 500,000.00 | 57,300.00 | 89.72 |
| 210807 | Газрын төлбөр | 219,700.00 | 219,700.00 | - | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 109,007,000.00 | 62,701,480.00 | 46,305,520.00 | 57.52 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,961,900.00 | - | 14,961,900.00 | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 94,045,100.00 | 62,701,480.00 | 31,343,620.00 | 66.67 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,996,000.00 | 3,024,000.00 | 13,972,000.00 | 17.79 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,996,000.00 | 3,024,000.00 | 13,972,000.00 | 17.79 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3,451,000.00 | - | 3,451,000.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,545,000.00 | 3,024,000.00 | 10,521,000.00 | 22.33 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 1.00 | 22.00 | 4.35 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 6.00 | - | 6.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | - | 16.00 | - |

## 2.5 Аудит хийсэн нэмэлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **510,588,275.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **510,588,275.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 510,588,275.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 71,232,875.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 71,232,875.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 7,779,613.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 5,449,461.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 840,210.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 404,052.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 285,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 800,890.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 20,166,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,535,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 504,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,126,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 234,460.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 234,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,373,100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,799,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,574,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 391,802,227.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 388,287,375.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,209,600.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 10,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,273,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 22,252.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 532,941,775.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 532,941,775.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 51,209,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 451,757,175.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 29,975,600.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,407.4 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 5,766.9 мянган төгрөгийн албан шаардлага, 16,640.5 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн. Тухайн байгууллагын алдаа зөрчил нь материаллаг түвшинг даваагүй болно.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй

### 3.2 Албан шаардлага

- Бүтэц орон тоо нь батлагдаагүй Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан томилон ажиллуулж 5 766.9 мянган төгрөгийн цалин тооцоолсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.Төсвийн шууд захирагч нь 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох, 14 дугаар зүйлийн 14.2.12.эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох" гэсэн заалт зөрчигдсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт</u>:*

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 8 650.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3.холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” гэсэн заалт зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх, акталж ажиллах

***2. Цалингийн данстай холбоотой асуудал***

Байгууллагад ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагчийн 792.0 мянган төгрөгийн ажлын хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутган төлөөгүй байна. Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.10.өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан, 7 дугаар зүйлийн 7.4.Энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын төрөлд дараах хүн албан журмаар даатгуулна" гэсэн заалт зөрчигдсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Цалингаас тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг хууль тогтоомжийн дагуу тооцож, үнэн зөв тайлагнаж хэвших

### *3. Зардлын  данстай холбоотой асуудал*

Хүүхдийн хөгжил оролцоо хөтөлбөрийн 7 198.5 мянган төгрөгийн зардлыг  зардлын ангилал харгалзахгүй бүх гарсан гүйлгээг нэг зардлаар тайлагнаж  зардал гүйлгэн зарцуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх, Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3.2.Зардлын онцлогийг харгалзан холбогдох УСНББОУС-ын шаардлагын дагуу зардлыг бүртгэнэ Сангийн сайдын 2023 оны 11 сарын 20-ны 211 тушаалаар батлагдсан "Ангилал шинэчлэн батлах журам"-ын 2-р хавсралтын " Төсвийн эдийн засгийн ангиалал" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийж зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Завсрын аудитын аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Анхан шатны баримт дутуу | 1 | 91.6 | 1 | 91.6 | | | | |
| Нийгмийн даатгал тайлагнаагүй | 1 | 19,540.0 | | | 1 | 19,540.0 | | |
| Үлдэх өртөггүй хөрөнгө | 1 | 10,535.2 | | | | | 1 | 10,535.2 |
| Биет тооллогоор байгаагүй хөрөнгө | 1 | 8,650.0 | | | | | 1 | 8,650.0 |
| Худалдан авах ажиллагаа хийгдээгүй | 1 | 20,000.0 | | | | | 1 | 20,000.0 |
| Бүтэц орон тоонд заагдаагүй ажил хавсран гүйцэтгэсэн | 1 | 5,766.9 | | | 1 | 5,766.9 | | |
| **Нийт дүн** | **6** | **64,583.7** | **1** | **91.6** | **2** | **25,306.9** | **3** | **39,185.2** |

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бүтэц орон тоо нь батлагдаагүй ажилтан ажиллуулж 5 766.9 мянган төгрөгийн цалин тооцоолсон байна. | 1 | 5,766.9 | | | 1 | 5,766.9 | | | | | | |
| Тэг үлдэгдэлтэй 8 650.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | 8,650.0 | | | | | 1 | 8,650.0 | | | | |
| Гэрээгээр ажиллагчийн 792.0 мянган төгрөгийн ажлын хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл тооцож суутган төлөөгүй байна. | 1 | 792.0 | | | | | 1 | 792.0 | | | | |
| 7 198.5 мянган төгрөгийн зардлыг зардлын ангилал харгалзахгүй зарцуулсан байна. | 1 | 7,198.5 | | | | | 1 | 7,198.5 | | | | |
| | 4 | 22,407.4 | | | | | 3 | | | | | |